



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 5/20

Хэрлэн сум

Г.Мөнх-Эрдэнийг түр орлон  
гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.10, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, Засгийн газрын 2011 оны 62 дугаартай тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ын 3.3, 3.3.4, 4.3, 4.3.3, 4.4, 5.3-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргыг томилогдох хүртэлх хугацаанд даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр тус газрын мэргэжилтэн Г.Мөнх-Эрдэнийг 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн томилсугай.

Хоёр. Г.Мөнх-Эрдэнэд цалингийн зөрүүг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үндсэн цалингаас тооцож олгохыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нягтлан бодогч /Л.Түмэнжаргал/-д зөвшөөрсүгэй.

Гурав. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Г.Мөнх-Эрдэнэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА